




Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 сарын 22-ны өдрийн 04/06 дугаар тогтоолын тавдугаар хавсралт

Компанийн нэр:	“Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК” ХХК	Баримт бичгийн код:	ТУЗ.Б.002-01
		Хувилбарын дугаар:	01
Баталсан огноо:	2022.12.22	Мөрдөж эхлэх огноо	2022.12.22
Батлав.	 Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ж.САНДАГСҮРЭН	Хуудасны тоо:	6

Баримт бичгийн нэр:

## КОМПАНИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Баримтын төрөл:	Дүрэм
Нууцын зэрэглэл:	Дотоод хэрэгцээнд
Зохицуулах үйл ажиллагаа:	Компанийн ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргах, энэ талаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, ногдол ашгийг тараах, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулах
Хариуцах хороо/дарга, гишүүн:	Аудитын хороо, дарга
Хуулбарыг:	ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, Компанийн Гүйцэтгэх удирдлага

Энэхүү баримт нь “Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК” ХХК-ийн өмч бөгөөд зөвшөөрөлгүйгээр ашиглах, хуулбарлахыг хориглоно.

## АГУУЛГА

НЭГ. ӨӨРЧЛӨЛТИЙН ТЭМДЭГЛЭЛ.....	2
ХОЁР. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	3
ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ.....	3
ДӨРӨВ. БАРИМТ БИЧИГ ХАРИУЦАГЧ.....	3
ТАВ. НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР.....	3
ЗУРГАА. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ЗАРЧИМ.....	3
ДОЛОО. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ ШИЙДВЭР ГАРГАХ.....	3
НАЙМ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ, АЖИЛЛАГАА.....	4
ЕС. ТАЙЛАГНАЛ.....	4
АРАВ. ХАРИУЦЛАГА.....	4

## НЭГ. ӨӨРЧЛӨЛТИЙН ТЭМДЭГЛЭЛ

№	Заалт	Өөрчлөлтийн бичилт	Шалтгаан	Баталгаажилт
1				
2				
3				
4				
5				
6				
7				
8				
9				
10				
11				
12				
13				
14				
15				
16				
17				
18				
19				
20				

Энэхүү баримт нь "Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК" ХХК-ийн өмч бөгөөд зөвшөөрөлгүйгээр ашиглах, хуулбарлахыг хориглоно.

## **ХОЁР. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

2.1. Энэхүү Ногдол ашгийн бодлого (цаашид “Бодлого” гэх)-ын баримт бичгийн зорилго нь “Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргах, энэ талаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, ногдол ашгийг тараах, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2.2. Энэхүү бодлого нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн журам болон холбогдох бусад дүрэм, журмуудад нийцсэн байх ба компанийн ногдол ашиг хуваарилах үйл ажиллагаанд мөрдөгдөнө.

2.3. Компани ногдол ашиг хуваарилах үйл ажиллагаанд урт хугацааны үр ашиг, хувьцаа эзэмшигчдийн нийтлэг эрх ашиг, тогтвортой хөгжлийг харгалзан үзнэ.

2.4. Үймээн самуун, байгалийн гамшиг, компанийн үйл ажиллагаанд материаллаг нөлөө үзүүлэх гадаад орчны өөрчлөлт, компанийн үйл ажиллагааны дотоод өөрчлөлт зэрэг давагдашгүй хүчин зүйл тохиолдсон үед компанийн ногдол ашгийн бодлогоо өөрчилж болно.

2.5. Ногдол ашиг хуваарилах бодлогыг өөрчлөх шаардлагатай гэж үзвэл ТУЗ саналаа боловсруулж Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулна.

## **ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ**

3.1. Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд, эрх бүхий албан тушаалтан үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

## **ДӨРӨВ. БАРИМТ БИЧИГ ХАРИУЦАГЧ**

4.1. Баримт бичгийг Аудитын хорооны дарга хариуцна.

## **ТАВ. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР**

5.1. Бодлогын баримт бичигт хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

5.1.1. “ногдол ашиг” гэж ашгийн хуваарилалтыг ойлгоно.

## **ЗУРГАА. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ЗАРЧИМ**

6.1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг үр ашигтай удирдаж ашгийн хэмжээг тогтмол өсгөн, ногдол ашгийг хуваарилан ажиллана.

6.2. Компани татвар төлсний дараах цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахдаа дараах зарчмыг баримтална Үүнд:

6.2.1. Ногдол ашиг төлсний дараа төлбөрийн чадвартай байх;

6.2.2. Тухайн жилд ашигтай ажилласан байх;

6.2.3. ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх;

6.2.4. Компани эргүүлэн авах үүрэг хүлээсэн үнэт цаасаа бүрэн авсан байх.

## **ДОЛОО. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ ШИЙДВЭР ГАРГАХ**

7.1. Ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон тооцооллыг ТУЗ гаргана. Тооцооллыг гүйцэтгэх удирдлагаас санал болгож болно.

---

Энэхүү баримт нь “Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК” ХХК-ийн өмч бөгөөд зөвшөөрөлгүйгээр ашиглах, хуулбарлахыг хориглоно.

7.2. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай саналаа Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 30 хоногийн дотор гаргана. Ногдол ашиг хуваарилахаар санал гаргаж байгаа тохиолдолд дараах зүйлийг шийдвэрийн төсөлдөө тусгасан байна. Үүнд:

- 7.2.1. Тухайн төрлийн нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ;
- 7.2.2. Ногдол ашгийг олгох огноо;
- 7.2.3. Олгох арга зам, хэлбэр;
- 7.2.4. Бусад холбогдох асуудал.

7.3. Ногдол ашиг олгох хэлбэр ба хугацаа нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцсэн, холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын баталсан журам, зааврыг зөвлөмжийг дагаж мөрдөнө.

7.4. Төлөөлөн удирдах зөвлөл ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан саналаа Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулан эцсийн шийдвэрийг гаргуулна.

### **НАЙМ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ, АЖИЛЛАГАА**

8.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг үндэслэн Ногдол ашиг хуваарилах үйл ажиллагааг ТУЗ-өөс зохион байгуулна.

8.2. ТУЗ-өөс ногдол ашгийг тараах өдрийг тогтоохдоо компанийн бизнес төлөвлөгөөтэй уялдуулан боломжит хугацааг харгалзана.

8.3. Компани нь ногдол ашиг хуваарилахдаа Компанийн тухай хууль, холбогдох журамд заасан нөхцөл шаардлагыг хангасан байна.

8.4. Компани нь өөрийн цахим хуудсанд ногдол ашгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг байршуулна.

### **ЕС. ТАЙЛАГНАЛ**

9.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашиг хуваарилалт, олголтын тайланг хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд тайлагнана.

9.2. Компани нь ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор зохицуулах байгууллагаас тогтоосон хугацаанд эрх бүхий байгууллагуудад мэдээлнэ.

9.3. Төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашиг хуваарилахгүй гэсэн санал гаргасан тохиолдолд энэ тухай үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнах үүрэгтэй.

### **АРАВ. ХАРИУЦЛАГА**

10.1. Хууль тогтоомж, холбогдох эрх бүхий байгууллагын ногдол ашиг хуваарилахтай холбоотой дүрэм, журмыг зөрчвөл буруутай этгээд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

10.2. Компани нь ногдол ашгаа заасан хугацаанд хувиарлаагүй тохиолдолд хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх бөгөөд үүнээс учирсан хохирлыг компани нөхөн төлнө.

10.3. Заасан хугацаанд ногдол ашгаа аваагүй нь тухайн хувьцаа эзэмшигчийн ногдол ашиг авах эрхийг үгүйсгэх, эсхүл тухайн компани ногдол ашиг олгохгүй байх үндэслэл болохгүй.

10.4. Энэхүү бодлого болон компанийн дүрэм холбогдох бусад бодлого, журмыг зөрчин ногдол ашиг хуваарилсан тохиолдолд хувьцаа эзэмшигчид тухайн ногдол ашгаа эргүүлэн өгөх үүрэгтэй.

-o0o-